

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Зун

*Цагийн сайхан зуны эхэнд
Газрын сайхан хангайн нуруунаа
Хөхөө шувуун урьхнаар донгодох үес
Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай
Ногооны униар огторгуй тулж, зэрэглээ мяралзахад
Хүлэг морь урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ
Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад
Залуу хүмүүсийн сэтгэл сэргэж, бие биесээ бодно
Үзэсгэлэнт уул, тунгалаг усан зуны цагт тэгш
Эрийн гурван наадам монголын манлай баясгалан
Хүүхэд багачуудын гийнгоолох дуун хөндий талд яруу
Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал
Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтна
Хээр хөдөөд таван хошуу мал дураараа бэлчинэ
Өрх бүрийн үүднээ айраг найрын үнэр сэнгэнэнэ
Ийм сайхан баясгалантай, тийм сайхан жаргалтай (Д.Нацагдорж)*

1. Эх нь тоочимж болохыг баталсан хэсгийг олоорой.
 - A. Хэрэг явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүүрнэн бичжээ.
 - B. Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргажээ.
 - C. Агуулга нь баримт жишээнд тулгуурлажээ.
 - D. Юмс үзэгдлийн гол шинжийг нарийн дэс дараалалтай зураглан бичжээ.
 - E. Шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурлажээ.
2. **“Бие биесээ бодно.”** гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг асуух өгүүлбэрийн өгүүлэхүүн болгон хувиргасан хэсгийг олоорой.

A. бодов уу	B. бодоорой	C. бодлоо доо	D. бод	E. бодоосой
-------------	-------------	---------------	--------	-------------
3. Цөм үг нь жинхэнэ нэрээр илэрсэн холбоо үгийг олоорой.

A. Айраг найр	B. Зөөлнөөр цуурайт	C. Өрх бүр
D. Бие биесээ	E. Энэхүү дэлхий	
4. **“Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаана.”** гэсэн өгүүлбэрийг шууд утга санаагаар хувиргасан хэсгийг олоорой.
 - A. Хүнд буурал үүлнээс хүлгэлзэн асгарах бүлээн бороо.
 - B. Дээвэр дээр хөх усан төвөргөөн нижигнэнэ.
 - C. Хөх бороо нэг л мэдэхнээ цэцэг элдсээр өнгөрөөд явчихна.
 - D. Үүлгүй шахам тэнгэрээс бүдүүн ширхэгтэй бороо их л сүртэй оров.
 - E. Бороо орж ургамал цэцэг дэлгэрэн, хорвоо дэлхийн өнгө сэргэнэ.
5. Дараах өгүүлбэрүүдээс эхийн санаанд холбогдолгүй хэсгийг олоорой.
 - A. Ногооны униар огторгуй тулж зэрэглээ мяралзахад
 - B. Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад
 - C. Алсын салхи жихүүн амьсгалаар тас няс хийхэд

- D. Хөхөө шувуу урьхнаар донгодоход
E. Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтахад
6. **“Хүлэг морь урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ.”** гэдэгтэй ойролцоо санаат хэлцийг олоорой.
A. Нуур амар бол нугас амар
B. Эцсэн моринд ташуур олон
C. Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа
D. Нутгийн шороо алт, нуурын ус рашаан
E. Сайн хүний үр, сүүт гүүний унага
7. Эхийн гол санааг илэрхийлсэн холбоо үгийг олоорой.
A. Цагийн сайхан
B. Айраг найр
C. Таван хошуу мал
D. Хүлэг морин
E. Хүүхэд багачууд
8. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай хэсгийг олоорой.
A. хээр хөдөө
B. хөхөө шувуу
C. хангайн нуруу
D. үзэсгэлэнт уул
E. хөндий тал
9. Эхийн сэдвийг тодорхойлсон өгүүлбэрийг олоорой.
A. Хөхөө шувуу урьхнаар донгодох үес
B. Хүлэг морин урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ
C. Эрийн гурван наадам монголын манлай баясгалан
D. Цагийн сайхан, зуны эхэн
E. Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цагт тэгш
10. **“Эрийн гурван наадам монголын манлай баясгалан”** гэсэн өгүүлбэрийг найруулгын ерийн зэрэгт хувиргасныг олоорой.
A. Уудам талд наадмын аялгуу зөөлнөөр цуурайтна.
B. Монголчуудын хамгийн том баяр бол эрийн гурван наадам.
C. Хүүхэд багачуудын гийнгоолох хөндий талд яруу.
D. Дэлгэр хангайн наадам дэнж хотойлгон эхлэв.
E. Наадмын цэнхэр асар сэвшээ салхинд дэрвэнэ.
11. Эхэд өгүүлэгчийн дотоод сэтгэлийн ямар үнэлэмж, өнгө аяс илэрсэн бэ?
A. Үйл байдал сэтгэлд зохистойг илэрхийлсэн
B. Үйл байдалд санаашран, уйтгарласан
C. Үйл байдлыг тааварлан барагцаалсан
D. Үйл байдлын таагүйг илэрхийлсэн
E. Үйл байдалд эргэлзэж тээнэгэлзсэн
12. **“Ногооны униар огторгуй тулж, зэрэглээ мяралзахад Хүлэг морь урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ”** гэдгийн мөр хоорондын холбоосыг солин найруулахад аль нь тохирох вэ?
A. тулд
B. тухай
C. зэрэгцээ
D. төлөө
E. эсвэл
13. **“Ногооны униар огторгуй тулж, зэрэглээ мяралзаад ...”** гэдгийг эрдэм шинжилгээний найруулгад зөв хувиргасан хэсгийг олоорой.
A. Ууршилт нь ихэвчлэн өглөөгүүр эсвэл нар буурсан үед ажиглагдана.
B. Униар татах үзэгдэл нь өдөр дундын үед бараг ажиглагдахгүй.
C. Газрын гадарга орчмын агаарын давхаргад үүссэн усны уур.
D. Агаар мандлаас дэлхийн гадарга дээр унаж буй хатуу шингэн төлвийн усны хэлбэр.
E. Ургамлаар дамжсан уурших үзэгдэл нь орчны барааг хязгаарлана.
14. Эхэд байгаа **“Урьхнаар донгодох”** гэсэн адилтгасан дүрслэлийн шинжийг олоорой.
A. байн байн
B. уулнаа
C. удаанаар
D. модноо
E. тааламжтайгаар
15. Эхээс **“Төрсөн нутгийг зүглэнэ.”** гэсэн өгүүлбэрийг дэлгэрүүлсэн үйлийн тодотгол буюу дэд дэлгэрүүлэгч гишүүн өгүүлбэрийг олоорой.
A. Ногооны униар огторгуй тулж
B. Зэрэглээ мяралзахад
C. Хүлэг морь урт янцгааж
D. Залуу хүмүүсийн сэтгэл сэргэж
E. Хөхөө шувуу урьхнаар донгодоход

16. **“Уудам талд наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтна.”** гэсэн өгүүлбэрийн нэрийн хамжсан тодотгол гишүүнийг салаалан хувиргасныг олоорой.
 А. найр наадмын В. намуухнаар С. хангинана D. саруул E. дуу
17. Аль хэсэгт зохиолчийн үнэлэмж илрээгүй вэ?
 А. Хүүхэд багачуудын гийнгоолох дуун хөндий талд яруу
 В. Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал
 С. Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай
 D. Хээр хөдөөд таван хошуу мал бэлчинэ.
 E. Ийм сайхан баясгалантай, тийм сайхан жаргалтай
18. **“Хүүхэд багачуудын гийнгоолох дуун хөндий талд яруу”** гэдгийг **“Хүүхэд багачуудын гийнгоолох дуун хөндий талд яруу сонсогдоно.”** гэж хувиргавал эхийн найруулгад өөрчлөлт гарах уу?
 А. Үг илүүдэж шүлгийн айзам хэмнэл алдагдана. В. Үг буруу сонгосон алдаа болно.
 С. Үг дутсан алдаа болно. D. “Яруу сонсогдоно” гэдэг нь учир зүйн алдаа.
 E. Дуу сонсогдож байгаа тул оновчтой.
19. Зуны улиралд холбогдолгүй хэсгийг олоорой.
 А. Хөхөө шувуу донгод В. Ногооны униар С. Эрийн гурван наадам
 D. Цэцгийн хур E. Өнөр сайхан төл
20. Эхэд ойролцоо утгатай байгаа үгсийг олоорой.
 А. донгодох, гийнгоолох, янцгаах В. мяралзах, гийнгоолох, цуурайтах
 С. дэлхий, огторгуй, уул D. зөөлнөөр, дураараа, нуруунаа
 E. тааламжтай, баясгалантай, жаргалтай
21. **“сэнгэнэнэ”** гэдгийн утгат хэсгийг зөв тайлбарласныг олоорой.
 А. сэн – идэвхтэй үйл язгуур, үйлийн үндэс
 В. сэнгэнэ - идэвхгүй дуурайх язгуур, үйлийн үндэс үүсгэх дагавар авсан
 С. сэнгэ – идэвхгүй дуурайх язгуур, жинхэнэ нэр бүтээх дагавар авсан
 D. сэнгэнэнэ – үүсмэл үйл үг, үйлдүүлэх хэвд, цагаар төгсгөх нөхцөлтэй
 E. сэ – идэвхгүй үйл язгуур
22. Өгүүлбэрийн цэгийн оронд тэмдэг нэрийг тохируулан нөхөөрэй.
 гэгээ тэртээ уулын цаад руу замхран орж, нэгэнтээ эргэн тойрон бүрий барай болов. (Д.Н)
 А. Үүрийн В. Цагаан С. Нарны D. Дээрх E. Тэр
23. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 Жинхэнэ нэр, үүсмэл бус, өгөх оршихын тийн ялгалд, хамаатуулах нөхцөлтэй.
 А. амьсгалаар В. улирал С. хажууд D. нүүртээ E. буцахад
24. Дараах таван үгээс төрөл биш утгат үгийг олоорой.
 А. хага В. хагар С. хагт D. хагац E. хагас
25. Эхийн дараах хэсэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.
Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад
Залуу хүмүүсийн сэтгэл сэргэж, бие биесээ бодно
 А. Бороотой өдөр өө ... гэж бухимдсан мэт зүүдгэр сэтгэлд нэг л хүнд. (Н.Ө)
 В. Манай нутгийн бороо салхи хөлөглөн ирдэг юм уу гэж, би бодно. (Н.Ө)
 С. Борооны түрүүч том том дусал шавхуурдан орсноо мөндөр болно.(Н.Ө)
 D. Бороотой өдөр хайрын сэтгэлд бодлын солонго татна. (Н.Ө)
 E. Гэнэт салхи гарч бороо, шороо аль нь орох гэж буйг бүү мэд тэнгэр бүрхэв. (Н.Ө)

26. Дараах гар утасны “мессеж” (зурвас) – ийн жишээ болох “**Hi, my naiz, yu bn daa, mani ni, lagshtee, ok**” гэх мэт этгээд, харь үг хэллэгт хийсэн зөв дүгнэлтийг олоорой.
- A. Утга зохиолын хэлний хэмнэх зарчим ингэж илэрнэ.
 B. Утга зохиолын хэлний хэм хэмжээг зөрчдөг үгс тул найруулгад тодорхой журамтай хэрэглэнэ.
 C. Иймэрхүү үг хэллэг нийгмийн хөгжлийг дагаж бий болдог үзэгдэл тул албан ярианд хэрэглэнэ.
 D. Яриа хөөрөөг хошин наргиантай болгодог тул утга зохиолын хэлний хэм хэмжээг зөрчихгүй.
 E. Бүгд монгол хэлний үгийн санд байгаа үг тул утга зохиолын хэлэнд хэрэглэнэ.
27. Дараах хэсгийн тодруулсан бүтээврийн (- хан⁴) баймж утгатай хамгийн ойр хэсгийг олоорой.
- Хөхөө шувуун урьхнаар донгодох үес*
Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай
- A. Чинийх долоо, минийх долоохон
 B. Тавьхан лангийн үнэтэй миний ээж хаачив?
 C. Хөвсгөрхөн цагаан үүл нь хөвөлзөнхөн нүүдэллэнэ.
 D. Голын хэдэн нарс ав адилхан өндөр, ав адилхан намхан ургажээ.
 E. Аавгүйхэн ботго нь араар тэнээд буйлна.
28. Дараах өгүүлбэрийн утга санааг эсрэг санаагаар солин найруулахад цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг ол.
- | | |
|------------------------------|------------------------------------|
| Хэрэв номын утгыг мэдэх хүн | Хэрэв номын утгыг мэдэх... хүн |
| Хэр мэт сайн шастирт дурлах. | Хэр мэт сайн шастирт дурлах. |
- A. гүй, үл B. маш, аарай C. ба, эс D. д, бөгөөд E. бас, жээ
29. Утга төгс өгүүлбэр бүтээхэд, цэгийн оронд аль бүтээвэр нь дарааллаараа тохирох вэ?
- Үхэр шар мөргө...н мал... хүнийг зугаа...уулна.**
- A. – үүл, - ын, - л B. – лц, - д, - р C. - лд, - чин, - ц D. - гд, - саг, - ц E. - лд, -аар, - ц
30. “- даа⁴” - г бахархах баймж утгаар хэрэглэсэн хэсгийг олоорой.
- A. Өөрийнхөө хургыг бол буцаасан даа, санаа муутай золиг. (Д.Б)
 B. Нэг оройн сааль юу ч биш гэж заяа нь бодохгүй дээ. (Д.Б)
 C. Чамай мууг даа. (Д.Б)
 D. Юугаар дутлаа гэх билээ дээ. (Д.Б)
 E. Анх удаа аав ээжийнхээ захидгий нь биелүүлсэн дээ.(Д.Б)
31. Дараах хэсэгт харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
- Цагийн сайхан зуны эхэнд**
Газрын сайхан хангайн нуруунаа
- A. 2 B. 3 C. 4 D. 5 E. 1
32. Цэгийн оронд зөв бичгийн дүрэм, утгын алдаагүй үгийг нөхөж бичээрэй.
- Намар болж айлууд**
- A. нүүдэллээ B. нүүдэллэлээ C. нүүдлээ D. нүүдлэлээ E. нүүдэлэлэлээ
33. “Зэрэглээ мяралзахад ...” гэсэн өгүүлбэрт өгөх оршихын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?
- A. Үйлийн эзнийг заах B. Үйлийн зорилго заах C. Орших орныг заах
 D. Үйлийн цагийг заах E. Агуулах сав багтаамжийг заах
34. Д.Мягмар “Үер” туужийн Дорлигийн дүрийг тодорхойлсныг олоорой.
- A. Ажил сайтын амьдрал сайн B. Муу хүн чөлөөнд, чоно бороонд
 C. Арвайн гурил ус даадаг, аавын хүү үг даадаг D. Баян нэг шуурганд, баатар нэг суманд
 E. Буянтай хүний бух нь тугаллах

35. Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана” шүлгийн дараах мөрийн цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг олоорой.

..... **харанхуйд тэнгэрийн заадал**
Гүүн зэл шиг сунайн
 **талын аяс хөндөж**
Алдуурсан унага шиг од

- A. Түнэр, харагдана, хөдөө, гялалзана
- B. Шөнийн, үзэгдэнэ, уудам, харагдана
- C. Тас, татна, тэнүүн, үзэгдэнэ
- D. Гүн, цайрна, амгалан, харвана
- E. Хав, байна, чимээгүй, гялтганана

36. “Монголын нууц товчоо” зохиолд Бөртэ үжин

“Үүнээс хойш **тэд**
 Үүл мэт биеийг чинь
 Үгүй болж одвол
 Үлдсэн их улсы чинь
 Үр хүүхдээр чинь мэдүүлэх үү?” хэмээхдээ “**тэд**” гэж хэнийг хэлсэн бэ?

- A. Чингисийн есөн өрлөг
- B. Ван ханы цэргүүд
- C. Хонхотоны хөвүүд
- D. Хэвтүүл цэргүүд
- E. Жамухын нөхөд

37. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлгийг олоорой.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠢᠴᠢᠭᠢᠨᠡᠬᠢᠶᠢᠭᠤᠨᠠᠭᠤᠰᠠᠳᠤᠰᠡᠪᠬᠦᠷᠪᠦᠯᠭᠢᠭᠢᠭᠣᠯᠣᠷᠣᠢ

- A. Ухаан тэвчээр хоёрт хүч байдаг.
- B. Ухаан тэвчээр хоёроос хүч гарна.
- C. Ухаан тэвчээр хоёр байсан газарт хүч буй.
- D. Ухаан тэвчээр хоёр байхгүй бол хүч үгүй.
- E. Ухаан тэвчээр хоёр бол хүч буйн шинж.

38. Цэгийн оронд тохирох дагаврыг олоорой. (Хоёр үгэнд ижил дагавар тохирно.)

- A.
- B.
- C.
- D.
- E.

ᠠᠨᠠᠴᠤᠨᠠᠭᠤᠰᠠᠳᠤᠰᠡᠪᠬᠦᠷᠪᠦᠯᠭᠢᠭᠣᠯᠣᠷᠣᠢ

ᠰᠢ ᠰᠢ ᠰᠢ ᠰᠢ ᠰᠢ

39. Монгол бичигт “- аач⁴” нөхцөл залгахад холбох эгшиг авах үг аль вэ?

- A. Суугаач
- B. Бодооч
- C. Хэлээч
- D. Хараач
- E. Босооч

40. “Хүлэг морь урт янцгаана.” гэсэн өгүүлбэрийн тодоор бичсэн үг аль нь вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

ᠬᠦᠯᠡᠭᠢ ᠬᠦᠯᠡᠭᠢ ᠬᠦᠯᠡᠭᠢ ᠬᠦᠯᠡᠭᠢ ᠬᠦᠯᠡᠭᠢ

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

- Санамж:** 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой

2.1. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- | | |
|--|--|
| a. Тэднүүс Батбаярыг дагаж гэгчийн үлгэрээр болох гэвэл дураараа болог. (Б.Р) | 1. илжиг модон хударгандаа |
| b. гэгчээр хүрээ эргэхээр гарсан Чимэг, Цэцэг хоёр хүрдний дэргэд зогсон ярилцаж тас тас инээнэ. (Ч.Л) | 2. дэмий суухаар тэмээ хариул |
| c. Дэндэв гуай, - За яахав ээ, гэж бандийн ааган дээр миний хашрыг нэмэхэд эрхээ биш ганц нэг бухал овоолчих юм гогодчих байлгүй! гэв. (Д.У) | 3. бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй |
| d. гэгчээр Итгэлтээс гуйхаас өөр арга олдсонгүй. (Ч.Л) | 4. олны олон таван цэн |
| e. гэгчээр жинчид гэв гэнэт зүгээр суух болсондоо уйтгарлан байж ядах болсон билээ. (Д.Н) | 5. галуу дуурайж хэрээ хөлөө хөлдөөнө |

2.2. Оновчтой харгалзуулан дүрслэх ур маягийг бүтээгээрэй.

- | | |
|-----------|-------------|
| a. Явган | 1. зэрэглээ |
| b. Дэлгэр | 2. хяруу |
| c. Торгон | 3. шуурга |
| d. Тэлмэн | 4. хангай |
| e. Саарал | 5. салхи |

2.3. Зохиолын дүрүүдийг ойролцоо шинжээр нь харгалзуулаарай.

- | | |
|---|--|
| a. Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс”
Цэрмаа | 1. Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Дэжид |
| b. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” Бадарч | 2. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” Дулмаа |
| c. Б. Явуухулан “Тэхийн зогсоол” харлаг тэх | 3. Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Цэрэн |
| d. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой”
жүжиг Нансалмаа | 4. С.Эрдэнэ “Өвгөн шувуу” Жав |
| e. Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс”
Дагдангийн эхнэр | 5. Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” На
түшмэл |

2.4. Дараах үгсийг утгын тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-----------------|--|
| a. Уулын бэл | 1. Уулын хажуугийн хуудас завсар |
| b. Уулын хяр | 2. Уулын орой нурууны журам |
| c. Уулын суга | 3. Уулын бэлийн доод этгээдийн газар |
| d. Уулын энгэр | 4. Уулын хажуугийн шувтрах налуу газар |
| e. Уулын хормой | 5. Уулын, өглөөний нар тусах этгээд |

Өвөл

Алсын салхин жихүүн амьсгалаар тас няс хийхэд
Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө
Өвлийн шөнө тэнгэрийн одон оч мэт гялалзахуйяа
Уудам талд жинчин хүний дуулах яруу
Өндөр уулсын оройд будан хүдэн зугаацаад
Өргөн талын хөндий нүд гялбам мэлцийхэд
Бэлчээрт гарсан малууд соргог үсийг гялалзуулан буцахад
Идэр залуу малчин түүнийг хураан исгэрнэ
Өндөр газрын хүйтэн тасхийм тасхийм, ясхийм ясхийм
Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай
Зургаан мичид орой дээр зулын гэрэл хажууд
Хөгшид өвгөд галыг базаан,хуучин үгсийг ярилцана
Өвөл, хавар, зун намрын дөрвөн улирал
Уул, усан, наран, саран лугаа нөхөрлөнө
Хүн бүр өтгөсийг үдэж, нялхсыг угтан
Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй (Д.Нацагдорж)